



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/392

Ховд

Баяр наадам тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.4, 60 дугаар зүйлийн 60.1.1, Үндэсний Их баяр наадмын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалт, Үндэсний Их баяр наадам зохион байгуулах хорооны тогтоолыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Тулгар төрийн 2231, Их Монгол улсын 816, Ардын хувьсгалын 101, жилийн ой, Ховд аймаг байгуулагдсаны 90, 91 жилийн ойн баяр наадмыг 7 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд, сумдын баяр наадмыг 7 дугаар сарын 10, 11-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Сум байгуулагдсаны түүхт тэгш ойн баяр тохиож буй Булган сумын 90 жилийн ойг 9 дүгээр сарын 8-10-ны өдрүүдэд, Дуут сумын 80 жилийн ойг 7 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд, Мөст сумын 80 жилийн ойг 7 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд, Үенч сумын 90 жилийн ойг 9 дүгээр сарын 05-07-ны өдрүүдэд, Эрдэнэбүрэн сумын 90 жилийн ойг 7 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэх сумдаас ирүүлсэн саналыг дэмжсүгэй.

3. Аймаг, сумдын баяр наадам зохион байгуулахад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад даалгасугай.  
Үүнд:


3.1. Баяр наадмын бэлтгэл ажлыг сайтар хангаж, нийтийн хэв журмын зөрчилгүй, унаач хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга нар, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, баяр наадам зохион байгуулах хороо, салбар хороодод;

-2-

3.2. Баяр наадмын үеэр болон амралтын өдрүүдэд байгууллага бүр хариуцлагатай жижүүр томилон ажиллуулахыг сумдын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, эрхлэгч нарт;

3.3. “Цэвэрхэн, хоггүй наадацаа” уриалгыг хэрэгжүүлж, хоггүй наадах, наадмын арга хэмжээний дараа зам, талбай, морины барианы газрын цэвэрлээнд идэвхтэй оролцохыг бүх шатны төрийн албан хаагчдад үүрэг болгож, ард иргэдэд зөвлөмж болгон хэрэгжүүлэхийг сумдын Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын дарга, эрхлэгч нарт;

4. Захирамжийг сүм, байгууллагуудад шуурхай хүргүүлж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлан, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баяр наадам зохион байгуулах хороо (Т.Дэлгэрсайхан), аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд) нарт даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ